

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/31.

Арвайхээр сум

Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын ажлын албаны бүрэлдэхүүнийг томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/383 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, комиссын ажиллах журам” -ын 1.6, 1.6.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын албаны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын албаны ажиллах чиг үүрэг, үйл ажиллагааг холбогдох журмын дагуу хэрэгжүүлж ажиллахыг ажлын албаны дарга (Н.Оюунтуяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал) -д үүрэг болгосугай.

4. Уг тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Тусгай зөвшөөрлийн ажлын албаны бүрэлдэхүүн томилох тухай” А/27 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301133

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны .11. -р сарын .22-ний
өдрийн .4/31 дугаар тушаалын
хавсралт



ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын албаны дарга:

Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн

Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Хяналт- шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн статистикч их эмч